

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2, “Ган Илч” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 124 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ган-Илч” ХХК-аас Дундговь аймгийн Сайнцагаан, Гурвансайхан, Говь-Угтаал, Өлзийт, Цагаандэлгэр, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Ган-Илч” ХХК /О.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тарифын газар /Б.Эрдэнэбулган/-д даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 152 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН, ГУРВАНСАЙХАН, ГОВЬ-УГТААЛ,
ӨЛЗИЙТ, ЦАГААНДЭЛГЭР, ДЭЛГЭРЦОГТ, САЙХАН-ОВОО СУМДЫН
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Дундговь аймгийн Сайнцагаан, Гурвансайхан, Говь-Угтаал, Өлзийт, Цагаандэлгэр, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,980.0
	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	70,260.0
		тогтмол	Төг/м ³
2	Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,048.0
	Сайнцагаан сумын үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	35,384.8
		тогтмол	Төг/м ³
	Бусад сумдын үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	46,417.5
		тогтмол	Төг/м ³
3	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "0" –ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	800.0